# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2022.12.12**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 оны Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 1.** ТӨВИЙГ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ, ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛНА. | | | | | | | |
| 1. | **МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 1.1.3.1** Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөнд тухай бүр тодотгол хийж, шуурхай дайчлах, хариу арга хэмжээг авах чадавхийг бэхжүүлнэ. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ЦССҮТ-ийн ажиллах журмыг 2021 оны А/17 тушаалаар шинэчлэн баталсан. ТУТ-ны төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн. | Төлөвлөгөөг шинэчлэн баталж, төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | 2022 онд ЦССҮТ-ийн тохиолдлын удирдлагын тогтолцооны хариу арга хэмжээний тодотгосон төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөний дагуу ТУТ-ны 7 багийн 7 хоног бүрийн ажлын тайланг нэгтгэн танилцуулж, Эрүүл мэндийн яам, УОК-ын шуурхай бүлэгт burtgel.mohs.mn, OBuleg2022@gmail.com хаягаар тогтмол хүргүүлж байна. Ерөнхий захирлын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/17 тушаалаар Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ЦССҮТ-ийн ажиллах журмыг шинэчлэн баталсаныг мөрдөж, галын аюулгүй ажиллагааны үзлэг зохион байгуулан дүгнэлт гаргуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн биелсэн. | 100% |
| 2. | **МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 1.1.3.1** | 50.0 | Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ | Burtgel.mohs.mn цахим системд | Гамшиг, нийгмийн эрүүл | Төв нь цус цусан бүтээгдэхүүний өдөр тутмын болон урт хугацааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Коронавируст халдварын үеийн нөөцийн хэрэглээг тооцох, бүрдүүлэх, хяналт тавьж бэлэн байдлыг хангана. | Улсын төсөв | | нөөцийн үлдэгдэл, орлого, зарлагын мэдээллийг 7 хоног бүр шинэчлэн мэдээлсэн. | мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангаж, 2-3 сарын шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна. | нөөц, гамшиг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн улсын нөөцийг бүрдүүлэн ажилладаг. 12 сарын 12 ны байдлаар Цус цусан бүтээгдэхүүний нөөц Улсын хэмжээнд дараах байдалтай байна. Үүнд:<br>● Улаан эсийн бүтээгдэхүүн 1505 нэгж<br>● Резус сөрөг улаан эсийн бүтээгдэхүүн 29 нэгж<br>● Хөлдөөсөн шинэ сийвэн 16240 нэгж<br>● К-Сийвэн 12109 нэгж<br>● Криопреципитат 767 нэгж<br>● Ялтаст эсийн өтгөрүүлэг 13 нэгж<br>Нийт 30663 нэгж цус цусан бүтээгдэхүүн буюу хүрэлцэхүйц нөөцтэй байна.<br><br>ЦССҮТ 12 дугаар сарын 12-ны байдлаар<br>● Улаан эсийн бүтээгдэхүүн 1156 нэгж<br>● Хөлдөөсөн шинэ сийвэн 10867 нэгж<br>● Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэн 587 нэгж<br>● К-Сийвэн 10936 нэгж,<br>● Криопреципитат 140 нэгж, нийт 23686 нэгж ЦЦБ-ий нөөц байгаа нь 2021 оны мөн үеэс 10%-78% хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>2022 оны 11 сарын 30-ны байдлаар Ковидын халдвараас сэргийлэх хамгаалах хэрэгсэлийн нөөц дараах байдалтай байна.<br><br>Эм эмнэлгийн хэрэгсэл,<br><br>- Нэг удаагийн малгай 1050 ш<br>- Нэг удаагийн халад 8054 ш<br>- Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 58595<br>- Үзлэгийн бээлий 67950 хос | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Улавч 329 хос<br>- Комбинзон 328 ш<br>- Хормогч 8 ш<br>- Нарийн шүүлтүүртэй амны хаалт N95 2744 ш<br>- Нүүрний хаалт 221 ш<br>- Ахуйн бээлий 37 хос<br>- Усны гутал 3 хос<br>- Аюултай хог хаягдлын уут 7896 ш<br>Ковид антиген тест, PCR орчин үлдэгдэлгүй байна. | |
| 3. | **МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 1.1.3.1**<br>Цус, цусан бүтээгдэхүүний Улсын нөөцийн хадгалалтын аюулгүй байдлыг хангаж, нөхөн сэлгэлтийг хийнэ. | - | ОБЕГ-тай хийгдсэн гэрээ, ажлын тайлан | Гэрээг дүгнэж, улсын нөөцөд бараа, материал худалдан авах нэмэлт гэрээ байгуулсан. | Гэрээний үүргийг хэрэгжүүлж, шаардлагатай бүтээгдэхүүний нөхөн сэлгэлтийг бүрэн хийсэн байна. | ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газартай хийсэн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж гэрээг дүгнэсэн. 2022 оны 5, 8, 12 дугаар саруудад нөөцийн хөлдөөсөн шинэ сийвэн, К сийвэнгийн нөхөн сэлгэлтийг 3 удаа хийж, тооллогоор баримтжуулсан. Гамшгийн нөөц төвийн цус цусан бүтээгдэхүүний хадгалалтанд харуул хамгаалалтын болон камерын хяналт, бүтээгдэхүүний хүйтэн хэлхээний хяналт тавин ажиллаж байна. Гамшгийн үеийн нөөц төвийн бэлэн байдлыг хангасан. Гамшгийн үеийн нөөц төв буюу төвийн 2-р байранд ОБЕГ-ын хөрөнгө оруулалтаар цус цусан бүтээгдэхүүний нөөцийн -35 хэмийн хүйтэн агуулах байгуулж ашиглалтад оруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | **СТЗ 1.1** Төвийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Батлагдсан стратеги төлөвлөгөө, 2022 оны хэрэгжилтийн хувь | Төвийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах арга хэмжээ 90 хувьтай хэрэгжсэн. | Төвийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг батлуулж, 2022 оны хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төвийн 2022-2025 оны хөгжлийн стратеги төлөвлөгөөний төслийг Удирдлагын академиас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран боловсруулсан. ЭМЯ-ны хариуцсан мэргэжилтнээр 3 удаа хянуулж, зөвлөгөөний дагуу засвар, сайжруулалтыг хийж байна. Стратеги төлөвлөгөөний 2022 онд төлөвлөсөн арга хэмжээний бүрэн биелэсэн байна. | 90% |
| 5. | **СТЗ 1.2** Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой дагалдаж гарах журмуудыг боловсруулж мөрдөнө. | - | Батлагдсан журам | 2021 онд Төвийн хүний нөөцийн хөгжлийг хангах 2021-2025 оны хөтөлбөр, Хүний нөөцийн төлөвлөлт /2021-2031/ батлагдсан. | ЦССҮТ-ийн Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох журам, Шагнал, урамшууллын журмыг баталж мөрдсөн байна. | Хөдөлмөрийн хуультай уялдуулан Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам, түүнтэй уялдан гарах Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох журам, Шагнал, урамшууллын журам, Архивын дүрэм батлуулж, Албан хэрэг хөтлөлтөд мөрдөн журмын төслүүд боловсруулав. Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Сургалт, хөгжлийн журам, Цалин хөлсний журам, Ур чадварын нэмэгдэл олгох журам, Мөнгөн урамшуулал олгох журам, Шагнал урамшлын журмыг тус тус батлагдан мөрдөж байна. | 100% |
| 6. | **СТЗ 1.1** 2022 онд цус, сийвэн, эс цуглуулалт болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн | 118.8 Улсын төсөв | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2021 онд ЦССҮТ-ийн хэмжээнд 26500 донороос цус, сийвэн, эс цуглуулахаар төлөвлөсөн. | 27000 донороос цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулж, 81145 нэгжээс багагүй ЦЦБ-ийг | 2022 онд 27000 донороос цус цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулна гэж төлөвлөснөөс 2022 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар 31258 донороос цус цуглуулж, 116%-ийн биелэлттэй байна. Нийт цуглуулалтын 65%-ийг суурин | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | Тайлант онд нийт 81145 нэгж ЦЦБ-ийг үйлдвэрлэсэн. | үйлдвэрлэж эмнэлгүүдийн захиалгыг 100% хангасан байна. | хэлбэрээр, 35%-ийг явуулаар цуглуулсан байна. 2022 онд 36 нэр төрлийн 81145 нэгж ЦЦБ үйлдвэрлэхээс 90494 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 111%-тай байна. | |
| 7. | **ЗГҮАХ 2.1.7; СТЗ 1.3**<br>Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2021 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. | Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллана. Аудитын зөвлөмжийн тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | 2022 оны Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах болон аудитын зөвлөмж шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан. Жилийн төлөвлөгөө бүрэн биелсэн байна. Үүнд:<br>- Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг үндэсний аудитын газарт хугацаанд нь хүргүүлсэн.<br>- Зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг мөрдөн, акруэль сууриар бүртгэлд тусгаж ажилласан.<br>- 2022 оны 2553.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг төлж барагдууллаа.<br>- Цалингийн тооцоолол хийхдээ алдаа гаргахгүй байхад анхааран ажиллаж байна.<br>- 2022 оны байдлаар ХАА-ны гэрээнд заасан төлбөрийг хэтрүүлээгүй, нийлүүлэгчээс бараа материалын чанар стандартын шаардлагыг хангуулан хүлээн авч байна.<br>- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор мэдээллийг бүрэн гүйцэд оруулж байна.<br>- ДЭМБ, ЭМДС-ийн санхүүжилтийг бүртгэн зарцуулах эрхийг журмын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу авч гүйцэтгэлийн тайланг цаг хугацаанд нь гаргаж өгч байна. Өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр авлагын тооцоог нийлж байталгаажуулан ажиллаж байна.<br>- Аудитын акт, албан шаардлагын биелэлтийг аудитын цахим программд оруулсан.<br>- Төсвийн хэмнэгдэх боломжтой зардлыг дутагдах зардалд гүйлгэн шилжүүлэх замаар болзошгүй өр төлбөрийн хэмжээг багасгаж байна.<br>- Төлбөрт үйлчилгээний орлогыг банкны шимтгэлийн дүнгээр бууруулахгүйгээр орлого, зардлыг бүрэн тусгаж байна. | |
| 8. | **СТЗ 1.1**<br>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг ханган, мэргэжлийн байгууллагаар шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийлгэнэ. | 40.0 Улсын төсөв | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний тайлан Шалгалт тохируулга, баталгаажуулалтын гэрчилгээ. | Эмнэлгийн тоног төхөөрөмжид 7 удаагийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийсэн. 2021 онд тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 8, багаж хэрэгслийн шалгалт тохируулга 60 удаа хийлгэсэн. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон өдөр тутмын засвар үйлчилгээг хийж төвийн үндсэн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангасан байна. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүрэн хийлгэж гэрчилгээ авсан байна. | 2022 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон өдөр тутмын засвар үйлчилгээг бүрэн хийж хэвийн ажиллагааг хангасан. Үүнд:<br>● Цусны албаны хэмжээнд ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн байдлыг үнэлэх зорилгоор асуумж судалгаа авсан. ЦСТ-д нийт 891 тоног төхөөрөмж байгаагаас эвдрэлтэй тоног төхөөрөмж 14 байгааг засварлах ажилд оруулах зөвлөмж хүргүүлсэн.<br>● Аферезийн аппаратны ACP POMP, Ƅoard жингийн тэнцүүлэгч шинээр сольж хэвийн үйл ажиллагааг хангасан.<br>● Цитоферезийн аппаратны CPU, боард, дэлгэцний уян холбоос | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр сольж ажиллагаанд оруулсан. Intercept аппаратны 6 сард 1 удаа хийх шарлагын 16 хос гэрлийг шинээр сольж урсгал засварыг хийсэн.<br>● Sigma 8кs хөргүүртэй хурилтуурын тагны цоожлогч мотор 2 ширхэгийг шинээр сольсон<br>● Серверийн өрөөнд кондейшний суурилуулсан<br>● Цахилгаан лифтны үзлэг үйлчилгээг гэрээт байгууллагаар тогтмол хийлгэж хэвийн найдвартай ажиллагааг хангасан<br>● Рентген аппаратын мэдрэгч авч цэвэрлэж үйлчилгээ хийсэн<br>● Үйлдвэрлэлийн тасгийн хоёр центрифугид балансын тохиргоо хийсэн<br>● -30 хэмийн өрөөний хөргөлтийн сэнсний тэжээлд үүсэж цахилгааны гэмтлийг мэргэжлийн инженерээр шуурхай засварлуулж хэвийн үйл ажиллагаанд оруулсан<br>● Ариутгалын өрөөний автоклав 96%- ийн спирт цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн<br>● Угаалгын өрөөний бүрэн автомат угаалгын машины усны хавхлага бөглөрлийг оношилж засварласан<br>Стандарт хэмжилзүйн газраар хэмжих хэрэгслийг шалгалт тохируулга, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталгаажуулалтад хамруулаж нийт-39 тоног төхөөрөмжид гэрчилгээ авсан. | |
| 9. | **СТЗ 1.4**<br>ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны тайланг хүргүүлнэ. | - | ДЭМБ-д хүргүүлсэн тайлан. | ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2018 оны тайланг хүргүүлсэн. | ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | ДЭМБ-аас 2 жил тутам авдаг Цус сэлбэлт судлалын салбарын тайланг бэлтгэсэн. Тайлан авах талаар мэдээлэл ирүүлээгүй бөгөөд тайлангийн линк илгээх хүсэлтээ мэйлээр хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. 2022 оны Цусны донорын Дэлхийн өдөр тэмдэглэн өнгөрүүлсэн талаарх техникийн болон санхүүгийн тайланг ДЭМБ-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт Монгол, Англи хэл дээр хүргүүлсэн. | 90% |
| 10. | **СТЗ 1.4**<br>Цус сэлбэлт судлалын салбарын 2021 оны статистикийн тайлан мэдээллийг нэгтгэн, ЭМХТ-д хүргүүлж, дүн шинжилгээ хийнэ. | - | Цус сэлбэлт судлалын салбарын 2021 оны мэдээ, тайлан | Цус сэлбэлт судлалын салбарын статистик тайлан, Эрүүл мэндийн үзүүлэлт 2020 гарын авлагын 9-р бүлэгт хэвлэгдсэн. | Цус сэлбэлт судлалын салбарын 2021 оны тайлан мэдээллийг ЭМХТ-д хугацаанд нь хүргүүлсэн байна. | Цусны салбар төвүүдээс батлагдсан маягтаар 2021 оны тайлан хүлээн авч хянан, нэгтгэсэн. Цус албаны 2021 оны статистик тайлан мэдээг ЭМХТ-д тайлангийн хугацаанд хүргүүлсэн. Сүүлийн 5 жилийн мэдээллийг үндсэн үзүүлэлтийг нэгтгэн баяжуулж “Эрүүл мэндийн үзүүлэлт 2021” эмхэтгэлд 2021 оны онцлох үйл ажиллагааны хамт хэвлүүлэхээр хүргүүлсэн. | 100% |
| 11. | **СТЗ 1.1**<br>Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын тайлан | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн болон авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хамаарал бүхий 9 этгээдийн ХАСХОМ, 5 этгээдийн ХАСУМ- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. | тогтоомж мөрдөгдсөн байна. | ыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, нийт 132 мэдэгдэл, тайлбар гаргуулж, хяналт тавин, шилэн данс, АТГ-ын цахим санд тус тус бүртгэсэн. АТГ-ын шалгалтад хамрагдсан зөрчилгүй байна.<br>2022 онд ЭБАТ болон 9 хамаарал бүхий этгээдийг ХАСХОМ, ХАСУМ мэдүүлгийн болон авлига, ашиг сонрхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийт ажилтныг АТГ-аас нийгмийн сүлжээнгээр хүргэж байгаа урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг ЦССҮТ хаалттай бүлгээр танилцуулж сургалт мэдээлэл хийсэн. Шинэ ажилтны чиглүүлэх сургалт, төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтад авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт орж, Төвийн нийт эмнэлгийн мэргэжилтнийг Ёс зүйн багц цагийн сургалтад хамруулсан. | |
| 12. | **СТЗ 1.1**<br>Төвийн сувилахуйн болон үйлчилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Сувилахуйн албаны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын дагуу 21 ажил төлөвлөн 100% биелсэн. | Сувилахуйн болон үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Сувилахуйн албанаас 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 4 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний биелэлт 100%-тай байна.Үүнд:<br>● Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад 2 сувилагч, Сувилахуйн эмнэлзүйн “Сургагч багшийн сургалтад 2 сувилагч суусан.<br>● “Цусны аюулгүй байдалд сувилагч нарын оролцоо” сэдэвт сургалтыг ХӨСҮТ-ийн 38, БГДЭМТ-ийн 34 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сувилагч тусгай мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>● Налайх дүүргийн ЦСТ-д Чанарын албатай хамтран дэмжлэгт хяналт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн<br>● Сувилахуйн мэргэжлийн “Тэргүүлэх” зэргийг шинээр 3 сувилагч, 1 сувилагч давтан хамгаалсан<br>● мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл 3 сувилагч сунгуулсан<br>● СҮА-ны бичиг баримтуудыг хянаж баталгаажуулсан.<br>● цэвэрлэгээ үйлчилгээ, угаалга, ариутгалд хэрэглэгдэх зүйлсийн тооцоо, гэрээ хийх, нийлүүлэлт болон зарцуулалтад хяналт тавьж ажилласан.<br>● Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдрийг Эрүүл мэндийн сайдын А/201 тоот тушаалын дагуу 3 зорилт 10 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулж тайланг хугацаанд нь хүргүүлсэн үүнд:<br>“Би цусны технологич сувилагч” контент, МҮОНРТ-ийн нэвтрүүлэгт 1 сувилагч, “Миний мэргэжил-технологич сувилагч” бүтээлийн уралдаан, “Сайн туршлага-ахмад настнуудаасаа суралцъя” ахмад настнууддаа хүндэтгэл үзүүлэх болон бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. | |
| 13. | **СТЗ 1.1** | 21.8 | Төлөвлөсөн арга хэмжээний | 2022 онд 3 чиглэлээр нийт | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн | 2022 онд Халдварын сэргийлэлт хяналтын баг 3 зорилтын хүрээнд нийт 19 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Халдварын сэргийлэлт хяналтын багийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | Улсын төсөв | хэрэгжилтийн хувь | 19 ажлыг хийхээр төлөвлөсөн. | хэрэгжиж, Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулж, сэргийлж ажилласан байна. | чиглэлийн үйл ажиллагаа төлөвлөн, 17’126’300 төгрөг зарцуулж төлөвлөгөө 100% биелэсэн байна.<br>ХСХ-ын үйл ажиллагаатай холбоотой 3 журам, 2 САЗ, 3 АЗ, Маягт 9, нийт 17 баримт бичиг шинэчлэн, мастер листийг шинэчилсэн.<br>Ажиллагсдын мэдлэг хандлагыг сайжруулах зорилгоор Халдварын сэргийлэлт хяналт, хог хаягдлын менежмент, цэвэрлэгээний стандарт, гар угаалт, гадаргуу халдваргүйжүүлэх зэрэг сэдвүүдээр 7 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 186 ажилтанг хамруулсан.<br>Ажиллагсдаас ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу өдрийн хоолоор үйлчилж, хоолны газрын эрүүл ахуй, хоолны амт чанарт тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>Ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг эрт илрүүлэгтэй хамтатган, УХТЭ-тэй хамтран 66 ажилтанг эрт илрүүлэгт насны ангилалын дагуу хамруулсан. Нэмэлтээр нийт ажилтнуудад элэгний хавдрын маркер, өндгөвчний хавдрын маркер, хавдрын ерөнхий маркер, бамбай булчирхайн үйл ажиллагаа илрүүлэх нийт 5 төрлийн шинжилгээг хийж, 5,760,000 төгрөг зарцуулав.<br>Мөн В вируст гепатитын эсрэг вакцины дархлаа тогтоцын шинжилгээ хийж, 21 ажилтныг В гепатитын эсрэг 3 тун вакцинд, томуугийн CGFLU 4 цэнт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | вакцинд нийт 51 ажилтанг тус тус хамруулсан. “Гар угаах Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, шавжгүйтгэл болон мэрэгчгүйтгэлийг хийлгэх болон бусад чиг үүрэгтэй холбоотой ажлуудыг хийж гүцэтгэсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | **СТЗ 1.1** Төвийн хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн санг баяжуулна. | - | Баяжилт хийгдсэн мэдээллийн сан | 2021 онд 14 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 13 нэр төрлийн үндсэн хөрөнгийг шинээр бүртгэж, 57 нэр төрлийн үндсэн хөрөнгийг мэдээллийн сангаас хасалт хийж шинэчилсэн. | Хөрөнгийн хөдөлгөөнийг хийж Санхүүгийн программын хөрөнгийн бүртгэлтэй хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн баазыг тохируулсан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай МУ-ын Засгийн Газрын 2020 оны 9 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2022 оны 64 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг эхний хагас жилийн тооллоготой хамтатган зохион байгуулсан. Тооллогын үр дүнгээр санхүүгийн программд шилжилт хөдөлгөөн, хасалт хийгдэж баталгаажуулах хөрөнгийн жагсаалт мэдээллийг гаргасан.<br><br>ЦССҮТ-ийн хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн санд бүртгэлтэй мэдээлэл технологийн 350 тоног төхөөрөмжийн мэдээллийг шинэчилж, программд бүртгэлгүй мэдээллийн технологийн 60 тоног төхөөрөмжийг нэмж бүртгэсэн. Уг системээр ирсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварын 8 хүсэлтийг шийдвэрлэж баримтжуулалтыг хийсэн. Бүртгэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг шинэчлэн, бүртгэлгүй 18 нэр төрлийн, актлагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлийг нэмж бүртгэх, хасалт хийх хөдөлгөөнийг хийж баталгаажуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2.** ЦУСНЫ ДОНОРЫН ЭГНЭЭГ ӨРГӨЖҮҮЛНЭ. | | | | | | | |
| 15. | **МУХТЖҮЧ 2.2.2; ЗГҮАХ 2.1.1; СТЗ 2.1**<br>Хүн амд зориулсан амьдралын зөв дадал хэвшлийн талаар мэдээ мэдээлэл хүргэнэ. | - | Шинээр бүтээсэн контентийн тоо<br>Олон нийтэд хүргэсэн МСС-ны төрөл, тоо | 2021 онд шинээр 7 контент бүтээж сургалт сурталчилгаанд ашигласан.<br>Цахим орчинд 100 гаруй мэдээлэл байршуулсан. | Шинээр 10-аас доошгүй контент бүтээж цахим орчинд байршуулсан байна. Ард иргэд, цусны донорт амьдралын зөв дадал хэвшил олгох сурталчилгааг хийж хандалтын тоог нэмэгдүүлсэн байна. | Хүн амд зориулсан амьдралын зөв дадал хэвшлийн талаарх сургалт мэдээллийг тогтмол хийсэн бөгөөд 11 контентийг бэлтгэж ашигласан байна. Үүнд:<br>● Доргохон-4, Доргохон-5 шторк, цусны донорын аппликейшн, нэмэлт дархлаажуулалтад хамрагдах тухай постер-2, ковид-19 халдвараас хамгаалах стэнт-5, Би цусны технологич сувилагч” контет нийт 11 төрлийн контэнт хийж 2 пейж, 1 групп хуудсанд байршуулсан олон нийтэд хүргэсэн.<br>● Ковид-19 вакцинжуулалт, Халдварт бус өвчлөлөөс урьдилан сэргийлэх, “Тамхины хор хөнөөл”, “Алхалтын ач тус”,” зэрэг 16 нэр төрлийн 258 мэдээ, мэдээлэл байршуулан нийт 66927 хүнд хүрсэн<br>● MASAM II төслөөр 60 хүнд цусны донор, болон амьдралын эрүүл зөв дадлын талаар мэдээлэл сургалт;<br>● Соба хаус ХХК-ны 16 ажилтанд “Эрчүүдийн эрүүл мэндийн талаар”, Цусны донорын амьдралын зөв дадалын талаар сургалт;<br>● ХААИС-ийн 300 гаруй оюутан багш ажилтанд цусны донорын ач холбогдол, зөв зохистой хоололтын талаар сургалт; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● МХЕГ-ын хотын харьяаны 9 байгууллагын 150 байцаагч, орон нутгийн 21 салбар байгууллагын 350 байцаагч нарт танхим болон цахим хэлбэрээр “Цусны донорын талаарх ерөнхий ойлголт” сэдвээр сургалт;<br>● ИНЕГ-ийн Аюулгүй байдал харуул хамгааллтын албны 89 ажилтанд цусны донорын тухай ерөнхий ойлголт, Цусны донорын хоололт, амьдралын зөв дадлын талаар сургалт мэдээлэл хийж ажилласан.<br>● МУЗН, монголын эрүүл мэндийн сэтгүүлчдийн ”Цагаан үзэг” холбоотой хамтран “Эрсдэлийн мэдээлэл харилцаа” сэдэвт сэтгэлүйч, аргазүйч нарт зориулсан чадавхжуулах сургалтанд хот болон орон нутгаас хамрагдсан нийт 63 хүнд “Цусны донорын тухай ерөнхий ойлголт”,”Эрүүл хоололт ба донор” сэдвээр сургалт хийсэн.<br><br>6 байгууллагын 1028 хүн хамрагдсан байна. | |
| 16. | **СТЗ 2.1** Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлнэ. | 25.0 Улсын төсөв Эрүүл мэндийг дэмжих сан | Цус цуглуулалтын тоо | 2021 онд цус цуглуулалтын тоо Улсын хэмжээнд 36888 байна. | Улсын хэмжээний цус цуглуулалтын тоо суурь үзүүлэлтээс нэмэгдсэн байна. | 2022 оны 12 сарын 15-ны байдлаар 10890 цусны шинэ донор элсүүлж цус цуглуулсан байна. Улсын хэмжээнд цус цуглуулалт 41058 байна. 2021 онд 8425 шинэ донор элсүүлж, 24370 цус цуглуулсан нь 2022 онд 81 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17. | **СТЗ 2.1** Сайн дурын идэвхтэн, бэлтгэх сургалт зохион байгуулна. | 5.0 Улсын төсөв МУЗН-ийн санхүүжилт | Сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | 2021 онд МУЗН-тэй хамтран 7 удаагийн сургалтаар 234 сайн дурын идэвхтэн бэлтгэсэн. | Сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтын тоо, бэлтгэсэн сайн дурын ажилтны тоо суурь түвшингээс буураагүй байна. | 2022 онд 5 удаагийн сургалтаар 242 Сайн дурын идэвхтэн бэлтгэсэн байна. Үүнд:<br>● 02 сарын 25-ны өдөр МДХ-ны 32 донор сурталчлагчид “Цусны донорын эгнээг өргөжүүлэхэд сайн дурын идэвхтэн бэлтгэх нь” сэдэвт давтан сургалт зохион байгуулан гэрчилгээ олгосон.<br>● АШУҮИС-ийн Био-Анагаахын тэнхимийн 3 ээлжийн оюутанд ЦССҮТ танилцуулах, цусны донорын талаарх ойлголтоор сургалт зохион байгуулан 52 сайн дурын идэвхтэн бэлтгэсэн.<br>● ХААИС-ийн Оюутны холбооны 18 гишүүнд “Явуулаар цус цуглуулах анхаарах зүйлийн талаар онол дадлага хосолсон сургалт зохион байгуулан СДИ бэлтгэсэн.<br>● МУЗН, монголын эрүүл мэндийн сэтгүүлчдийн ”Цагаан үзэг” холбоотой хамтран “Эрсдэлийн мэдээлэл харилцаа” сэдэвт сэтгэлүйч, аргазүйч нарт зориулсан чадавхжуулах сургалтанд хот болон орон нутгаас хамрагдсан нийт 63 хүнд “Цусны донорын тухай ерөнхий ойлголт” сэдвээр сургалт зохион байгуулан 60 сайн дурын идэвхтэн бэлтгэсэн.<br>● МУЗН-ийн вэбсайт-д байршуулсан цахим сургалтаар 8 дүүргийн 80 сайн дурын идэвхтэн “Цусны донорын ерөнхий ойлголт”, ”Цус цуглуулалтын талаар” 2 онолын сэдвээр хамрагдаж СДИ-ний батламж авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18. | **СТЗ 2.2** Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэнэ. | 1.0 Улсын төсөв Төрийн болон ТББ | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэсэн тайлан. | 2021 оны 1 дүгээр сарын 3-нд Цусны донорын үндэсний өдрийг зохион байгуулж донор алдаршуулсан. | Цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчилж, тэднийг алдаршуулсан байна. | Төвийн санаачлагаар жил бүрийн 1 дүгээр сарын 3-ныг “Цусаа бэлэглэх үндэсний өдөр” болгон тэмдэглэж, ард, иргэдийг цусаа бэлэглэх донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон нийтэд алдаршуулах арга хэмжээг зохион байгуулдаг.<br><br>Цусаа бэлэглэх Үндэсний өдрийн хүндэтгэлийн арга хэмжээг JCI Монгол ТББ хамтран зохион байгуулж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Үндэсний өдрөөр: 204 удаа цусаа бэлэглэсэн Топ донор-1, Алтан донор-1, Мөнгөн донор-1, “Хүрэл донор” цол тэмдэг-1, “Бахархал-50” тэмдгээр-1, “Бахархал-40” тэмдгээр-1, Бахархал-30” тэмдгээр-1, “Бахархал-20” тэмдгээр-1 нийт 8 донорыг, 2021 оны “Онцлох донор”-оор 2 донорыг шалгаруулж шагнаж алдаршуулан хамтран зохион байгуулагч JCI Капитал салбар байгууллагын гарын бэлэг гардууллаа. 2021 оны тэргүүний “Донор хамт олон”-оор ЗХ-120 анги, “Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч байгууллага”-аар Монос ХХК, тэргүүний “Донор элсүүлэгч байгууллага”-аар БЗД-ийн УЗДҮХ-ны дэргэдэх ЗУЗ-ийг тус тус тодруулж шагналаа. МУЗН-ийн Энэрэнгүй үйлстэн одонгоор -1, Нигүүлсэл Алтан медалиар 1, Нигүүлсэл Мөнгөн медалиар -2, Шилдэг залуу медалиар -1 донор, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | донорын үйлсийг дэмжигч байгууллагын төлөөллийг тус тус шагнаж урамшууллаа.<br><br>Салбар байгууллагууд 1 сарын турш аян зохион байгуулж 115 хүн цусаа хандивласан.<br>Мэдээлэл сургалт, сурталчилгааг 240 хүнд цахимаар, 115 хүнд биечлэн хүргэсэн.<br>Eagle TV “Зочны цаг” нэвтрүүлэг, Төр.мн 40 минутын лайв хийж 2 видео мэдээлэл болгон төвийн пейж хуудсанд тавигдсан.<br>Үндэсний өдрийн арга хэмжээний талаар 6-TV, 5 сайтаар мэдээлэл олон нийтэд хүргэж, 3 пейж нэг групп хуудсанд 31 мэдээлэл тавьж 19464 хүнд хүрсэн.<br>Алдаршуулалтын мэдээлэл 5тавыг тавьж 28474 хүнд хүрсэн. | |
| 19. | **СТЗ 2.2** “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг зохион байгуулна. | 10.0 Улсын төсөв ДЭМБ-ын санхүүжилт | Цусны донорын Дэлхийн өдрийг зохион байгуулах удирдамж, тайлан. | 2021 оны 6 сарын 14-нд Цусны донорын Дэлхийн өдрийг цахим болон танхимаар зохион байгуулсан. | ДЭМБ-ын 2022 оны удирдамжийг олон нийтэд сурталчилж, Цусны донорын Дэлхийн өдрийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлсэн байна. | Цусны донорын Дэлхийн өдөр” –ийн 19 дэх удаагийн арга хэмжээг “Цусаа бэлэглэж, эв нэгдлийг эрхэмлэн бусдын амь насыг аварцгаая” уриан дор ЭМЯ, МУЗН-тэй хамтран орон даяар зохион байгуулсан. Улсын Их Хурлын дарга “Цусны донорын дэлхийн өдөр”-т зориулсан арга хэмжээнд оролцож, хүрэлцэн ирсэн хүндэт донорууд, зочид төлөөлөгчдөд мэндчилгээ дэвшүүллээ. Мөн тэрээр цусаа бэлэглэж, ард иргэдийг цусаа өгч, бусдын амь насыг аврах үйлсэд нэгдэхийг уриалсан бол Эрүүл мэндийн сайдын ахлах зөвлөх, Бодлого | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөлтийн газрын дарга нар хүрэлцэн ирж, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч цахим мэндчилгээ дэвшүүлж баяр хүргэлээ. МҮОНРТ-ийн ерөнхий захирал, МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нар баяр хүргэж, нийт ард иргэд, байгууллага хамт олныг цусны донорын үйлсэд уриалсан.<br><br>Цусны донорын Дэлхийн өдөр” -өөр донорын үйлсийг дэмжиж хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, цусны доноруудыг шалгаруулан шагнаж алдаршуулсан.<br><br>2022 оны Цусны донорын Дэлхийн өдрөөр шинээр 160 Хүндэт донор төрснөөс 91 нь Нийслэлээс тодорсон ба Хамгийн залуу Хүндэт донор 20 настай Жавхлангийн ГЭГЭЭРЭЛ-ийг онцлон алдаршуулж, Хүндэт доноруудад үнэмлэх тэмдэгийг хүндэтгэлтэйгээр гардуулан өгч талархал илэрхийллээ.<br><br>Цус сэлбэлт судлалын үндэсний төв энэхүү ёслолын арга хэмжээтэй хамтатган Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулаад зогсохгүй Коронавируст халдвар цартахлын үеийн болон улирлын хамааралтай цусны нөөц буурахаас урьдчилан сэргийлэх, авлагагүй сайн дурын цусны донорын үйлсийг сурталчлан таниулах зорилгоор хувь хүн, иргэд байгууллага хамт олонд хандсан сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх 21 хоногийн “ЦУСАА | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | БЭЛЭГЛЭЖ, ЭВ НЭГДЛИЙГ ЭРХЭМЛЭН БУСДЫН АМЬ НАСЫГ АВАРЦГААЯ” аяныг эхлүүллээ.<br><br>ЦДДӨ-ийн цахим арга хэмжээг Төр.мн мэдээллийн сайт тус төвийн пейж хуудсаар шууд дамжуулж 5377 хүн үзэж, 40 гаруй сэтгэгдэл үлдээсэн байна. ETV телевиз, Төр.мн, МҮОНРТ, Эгүүр.мн, TW телевиз, Өлзий телевиз, Өдрийн сонин сайт, Сэргэлт.ком, TV9, Малчин телевиз, Парламент телевиз, МҮОН Радио зэрэг хэвлэл мэдээллийн 12 байгууллага хүрэлцэн ирж мэдээ бэлтгэсэн байна. Төвийн веб сайт, Амьдрал бэлэглэе, Донор та баатар группп, Цус сэлбэлт судлалын үндэсний төв пейж хуудсаар ёслолын арга хэмжээ болон 2022 оны шилдэгүүд, хүндэт донорuудыг алдаршууллаа.<br><br>2022 онд ДЭМБ-ын санхүүжилтээр цусны донорын Дэлхийн өдрийг угтан цусны донорын үйлсийг сурталчлах сургалт сурталчилгааны зөвлөмж 2700ш, плакат 710ш, нугалбар 3000, мемо 450 ширхэг материалыг хэвлүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна /тайланг хавсаргав/. | |
| 20. | **СТЗ 2.2** “Цусаа бэлэглэх өдөр”-ийг 2-12 дугаар саруудад зохион байгуулна. | 11.0 Улсын төсөв Эрүүл мэндийг дэмжих сан | Цусаа бэлэглэх өдөр тэмдэглэсэн тайлан. | 2021 онд Цусаа бэлэглэх өдрийг 11 удаа зохион байгуулж цусны донор, донор хамт олныг | “Цусаа бэлэглэх өдөр”-ийн арга хэмжээг 11 удаа зохион байгуулж цусны донор, донор хамт олныг шагнаж | Ард, иргэдийг донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон нийтэд алдаршуулахад зорилготой Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-ийн 11 удаагийн арга хэмжээг "Сэтгэлийн 1000 үйлс " НҮТББ (7 дахь удаа), ХААИС, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төрийн болон ТББ | | шагнаж алдаршуулсан. | алдаршуулсан байна. | "Монголын аялал жуулчлалын холбоо" НҮТББ (6 дахь удаа), МУЗН (8 дахь удаа) Хаан банк, Монголын үнэртэй усанд дурлагсдын клуб, Грийн химистри ХХК, Улаанбаатар сматр карт ХХК (7 дахь удаа), Төрийн банк, МУЗН Хүүхэд залуучуудын хөдөлгөөн, МДХ ТББ (7 дахь удаа) хамтран зохион байгууллаа.<br><br>Сар бүрийн 3 Цусаа бэлэглэх өдрөөр:<br>- Мөнгөн донороор -4,<br>- Хүрэл донороор -18,<br>- Бахархал 10 тэмдэгээр -33<br>- Бахархал 20 тэмдэгээр -21,<br>- Бахархал 30 тэмдэгээр -16,<br>- Бахархал 40 тэмдэгээр -14,<br>- Бахархал 50тэмдэгээр -15<br>нийт 125 донорыг тодруулж шагнаж алдаршууллаа.<br><br>Мөн Нийслэлийн 383 жилийг тохиолдуулан 100-с дээш удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн 4 донорыг Улаанбаатар хотын Хүндэт тэмдэг, 3 донорыг Нийслэлийн тэргүүний ажилтан цол тэмдэг, 2 донорыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн “Жуух бичиг” шагнасан байна.<br><br>Тухайн өдрүүдэд цус өгсөн доноруудад төвөөс бахархал тэмдэг, бүлгийн тэмдэг, аяга, флаш, мемо, маусны суурь, дорго зэрэг сургалт сурталчилгааны зүйлээр урамшуулж сурталчилгаа хийлээ.<br><br>Уг арга хэмжээний үеэр ивээн тэтгэж хамтран ажилласан Сүү ХХК 508000 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөг, И-Монос ХХК 960000 төгрөг, Монголын аялал жуулчлалын холбоо НҮТББ 300000 төгрөгийн эрхийн бичиг, Ulker Mongolia 667400 төгрөг, МУЗН 688700 төгрөг, ТМВ ХХК 200 улаан чавганы цай, Хаан банк 360000 төгрөг, Наран Бьюти ворлд, Ив-Роше Монгол,Таван Богд Интернэшл Локситан, АМОС 2569000 төгрөг, Chi forest Mongolia 500000 төгрөг, Грийн химистри ХХК 1200000 төгрөг, Улаанбаатар Смарт Карт ХХК 385000 төгрөг, Төрийн банк 320000 төгрөг, МДХ ТББ 23500 төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүний дээж, эрхийн бичгээр цусны доноруудыг шагнаж урамшууллаа. | |
| | | | | | | MNB, TV9, MNC TV, МҮОНРТ, ETV, Үндэсний радио, Төр.мн, МҮОНРТ, Монгол HD. Үндэсний шуудан, TV7, TV5, ТМ телевиз, UBS, SBN,TV6,TV5, Erin news.mn, Сүлд ТВ зэрэг давхардсан тоогоор 46 хэвлэл мэдээллийн байгууллагад ерөнхий захирал, Eagle TV-ийн зочны цагийн нэвтрүүлэг, Малчин ТВ-ийн шууд нэвтрүүлэг, МҮОНРТ-д 5 эмч мэргэжилтэн цусны донорын талаар сурталчилгаа мэдээлэл хийсэн байна. | |
| | | | | | | Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Амьдрал бэлэглэе пейж хуудас Донор та баатар групп хуудсанд донор алдаршуулах, Цусаа бэлэглэх өдрийг угтсан эвэнт, мэдээлэл байршуулж олон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийтэд хүргэж, цусны донорыг алдаршуулсан. | |
| 21. | **СТЗ 2.3** Хүндэт доноруудад нийгмийн халамж үзүүлэхэд дэмжлэг үзүүлж, бүртгэл мэдээллийн санг баяжуулна. | - | Хэрэгжүүлсэн ажлын тайлан | 2021 онд болзол хангасан Хүндэт донорын нэрсийг холбогдох яаманд хүргүүлсэн. Нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих автобусны карт болон мөнгөн тусламж авах, сувилалд амрах эрхийн тодорхойлолтыг олгосон. | Хүндэт доноруудад олгох нийгмийн халамж үйлчилгээний тодорхойлолтыг цахимжуулж, мэдээллийн санг үүсгэн, тогтмол шинэчилсэн байна. | Хүндэт доноруудын бүртгэл мэдээллиийг шинэчлэх, баяжуулах ажлыг тогтмол хийж байна. 2022 онд улсын хэмжээнд Хүндэт донор болсон нийт 183 донорын судалааг нэгтгэн ХНХЯ-д хүргүүлсэн. Улаанбаатар хотын 1963-2000 оны 988 хүндэт донорын мэдээлэл цаасан хэлбэртэй байсныг PDF хэлбэрт шилжүүлж хадгалсан.<br><br>Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн хүрээнд тус төвөөс хүндэт доноруудад олгодог нийгмийн халамж үйлчилгээний тодорхойлолтыг цахимжуулах, e-Mongolia системд оруулах ажлыг ХНХЯ, холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлэхээр ажиллаж байна. Цусны хүндэт донор сувилуулах, ахмад хүндэт доноруудад хөнгөлөлт, мөнгөн тусламж үзүүлэх тодорхойлолтыг нийт 230 донорт олгосон. Нийслэлийн хүндэт донор иргэнийг нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр хөнгөлттэй үнээр зорчуулах тухай гэрээний хүрээнд нийт 106 донорт шинээр болон дахин олголтын үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 3.** ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАНА. | | | | | | | |
| 22. | **СТЗ 3.10** | - | Гэрээний тоо | 2021 онд нийт 62 эмнэлэгтэй цус, | Эрүүл мэндийн байгууллагыг | УБ хотын хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн нийт 62 эмнэлэгтэй ЦЦБ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Эрүүл мэндийн байгууллагыг цус, цусан бүтээгдэхүүнээр хангаг нийлүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | | | цусан бүтээгдэхүүн хангаг нийлүүлэх гэрээ байгуулж ажилласан. | цус, цусан бүтээгдэхүүнээр хангаг нийлүүлэх гэрээ байгуулж зөрчилгүй ажилласан байна. | нийлүүлэх гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавинажиллаж байгаа бөгөөд гэрээний үүргэтэй холбоотой зөрчил илрээгүй байна. | |
| 23. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 3.10** Төвийн чанарын хөгжлийн хөтөлбөрийн 2022 оны хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг хангана. | - | 2022 оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Чанарын хөгжлийн хөтөлбөрийн 2021 оны тайланг нэгтгэн ЭМХТ-д хүргүүлсэн. Тайлангийн хэрэгжилтийн хувь 98.0. | Чанарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайланг ЭМХТ-д хүргүүлсэн байна. | Төвийн чанарын хөгжлийн хөтөлбөрийн 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 31 үйл ажиллагааны хэрэгжилт 98,3% биелсэн ба төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 2016 оноос эхлэн нэвтрүүлсэн 2 нэгж улаан эс цуглуулах шинэ технологи бүрэн нутагшиж чадаагүй байна. Чанарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжилтийн тайланг ЭМХТ-д хүргүүлсэн. | 100% |
| 24. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 3.2** Цуглуулсан цусны нэгж бүрт цусны АВО, Резус, Келл бүлгийг тодорхойлж, баталгаажуулна. | 11.3 Улсын төсөв | АВО, Резус, Келл бүлэг тодорхойлсон хувь | 2021 онд цуглуулсан цусны нэгж бүрт АВО, Резус, Келл бүлгийг 100 хувь тодорхойлж, баталгаажуулсан . | Цуглуулсан цусны нэгж бүрт АВО, Резус, Келл бүлэг баталгаажуулах шинжилгээг 100% хийсэн байна. | 2022 оны 11 сарын 30-ны байдлаар нийт 29444 цуглуулсан цусны нэгжид АВО, Резус, Келл бүлэг тодорхойлох шинжилгээг хийсэн. Үүнээс резус сөрөг 126, келл эерэг 113 донорт баталгаажуулах шинжилгээг хийсэн байна. | 100% |
| 25. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 3.2** Цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих | 2.230.8 Улсын төсөв | Гепатит В, С, ХДХВ тэмбүү илрүүлэх шинжилгээг фермент холбоот | 2021 онд 27264 донорын цусанд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг | Нийт цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг | 2022 оны 11 сарын 30-ны байдлаар нийт 29444 цуглуулсан цусны нэгжид цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг ФХЭБУ аргаар 100% хийж, сөрөг гарсан 28897 донорын сорьцонд ПГУ шинжилгээ, эерэг гарсан 547 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | халдвар илрүүлэх шинжилгээг хийнэ. | | эсрэгбиеийн урвал, ПГУ, хемолюминесценцийн аргаар шинжилгээ хийсэн хувь | фермент холбоот эсрэгбиеийн урвалын аргаар хийсэн.<br>ФХЭБУ аргаар Эерэг гарсан 743 сорьцыг 100% хемолюминесценцийн аргаар нэмэлт шинжилгээг хийсэн. Сөрөг гарсан 26257 донорын сорьцод ПГУ шинжилгээг хийж баталгаажуулсан | ФХЭБУ аргаар 100% хийж, сөрөг гарсан донорын сорьцонд ПГУ шинжилгээ, эерэг гарсан донорын сорьцод хемолюминесценцийн аргаар нэмэлт шинжилгээг 100% хийсэн байна. | донорын сорьцод хемолюминесценцийн аргаар нэмэлт шинжилгээг 100% хийсэн байна. | |
| 26. | **СТЗ 3.2** Байнгын доноруудад ферритин тодорхойлох шинжилгээг шинээр нэвтрүүлнэ. | 11.9 Улсын төсөв | Шинжилгээнд хамруулах шалгуур хийгдсэн шинжилгээний тоо | Ферритин тодорхойлох шинжилгээг хийж байгаагүй. | 500 байнгын донорт ферритин тодорхойлох шинжилгээ хийж цус багадалтыг тодорхойлсон байна. | Ферритин тодорхойлох оношлуурын захиалгыг хийж, Шинжилгээний аргын САЗ-ыг боловсруулсан. Ферритин үзэх донорын шалгуур үзүүлэлтийг гаргаж, давхардсан тоогоор тогтмол хугацаанд цусаа өгдөг 500 байнгын донорын сорьцонд ферритин тодорхойлох шинжилгээг хийж, хариуг цахимаар олгосон. | 100% |
| 27. | **СТЗ 3.11** Явуулын цус цуглуулах үйл ажиллагаанд зориулалтын орыг хэрэглээнд нэвтрүүлнэ. | - | Явуулын цус цуглуулалтанд зориулалтын ор ашигласан хувь | Явуулд зориулалтын ор ашигладаггүй. | Явуулын хэлбэрээр цус цуглуулах үйл ажиллагааны 10 хувьд зориулалтын ор | 2022 онд 22 удаагийн явуулд зориулалтын орыг хэрэглэж 1922 донороос цус цуглуулсан. Явуулаар нийт 10485 донороос цус цуглуулсан бөгөөд зориулалтын ор ашигласан цуглуулалт 18.3% эзлэж байна. Зөөврийн орыг явуул зохион байгуулах байгууллагад өмнөх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ашигласан байна. | өдөр байршуулах ажлыг ИТТ-тай хамтран зохион байгуулсан. Зөөврийн орыг хэрэглэснээр донорт тав тухтай орчныг бүрдүүлж, донорын аюулгүй байдал, цус өгсний дараах сөрөг хариу урвалаас сэргийлэх ач холбогдолтой байна. | |
| 28. | **СТЗ 3.10** Ердийн хэрэглээний цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн тогтвортой байдлыг хадгална. | - | Сийвэнгийн болон улаан эсийн бүтээгдэхүүний нөөцийн тоо хэмжээ | 2021 оны эцэст улаан эсийн бүтээгдэхүүний 1200 нэгж, сийвэнгийн бүтээгдэхүүний 16000 нэгжийн нөөцтэй байсан. | Сийвэнгийн бүтээгдэхүүн 16000 нэгж, улаан эсийн бүтээгдэхүүн 1200 нэгжээс багагүй байхаар нөөцийг бүрдүүлсэн байна. | 2022 оны 12 сарын 15-ны байлаар Сийвэнгийн бүтээгдэхүүн 22213 нэгж, улаан эсийн бүтээгдэхүүн 1225 нэгж нөөцийг бүрдүүлж ердийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. | 100% |
| 29. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 3.4** Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлж хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 592.5 Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | 2021 онд эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлж хөлдөөсөн шинэ сийвэнгийн 2368 нэгж (9,8%) бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлж хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэлийг 3600 нэгж буюу 15% болгож нэмэгдүүлсэн байна. | 2022 оны 12 сарын 15-ны байдлаар 2361 нэгж эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлж хөлдөөсөн шинэ сийвэнгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. 2022 оны тендерийн бараа материал хил, гаалийн нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс шалтгаалж зорилтот түвшинд хүрээгүй. Өмнөх жилээс үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 3.4** Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 198.0 Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | 2021 онд эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 366 нэгжийг үйлдвэрлэсэн. | Эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 490 нэгж болгож үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн байна. | 2022 оны 12 сарын 15-ны байдлаар 255 нэгж Эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг үйлдвэрлэсэн. 2022 оны тендерийн бараа материал хил, гаалийн нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс шалтгаалж зорилтот түвшинд хүрээгүй. | 90% |
| 31. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 3.4** Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 126.3 Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | 2021 онд цагаан эсгүйжүүлсэн улаан эс 2405 нэгж (9%)-ийг үйлдвэрлэсэн байна. | Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн үйлдвэрлэлийг 5351 нэгж буюу 20% болгож нэмэгдүүлсэн байна. | 2022 оны 12 сарын 15-ны байдлаар 4620 нэгж цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. 2022 оны тендерийн бараа материал хил, гаалийн нөхцөл байдалтай холбоотойгоор хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс шалтгаалж зорилтот түвшинд хүрээгүй. Үйлдвэрлэл 2021 оны мөн үеэс 1,8 дахин өссөн байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32. | **СТЗ 3.2**<br>Молекул биологи, иммунологи, иммуногематологи, бүлэгнэлтийн чиглэлээр олон улсын чанарын гадаад үнэлгээнд хамрагдана. | 6.0 Глобал сан | Чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан гэрчилгээ | 2021 онд бүлэгнэлтийн шинжилгээгээр 1 удаа, иммуногематологийн чиглэлээр 3 удаа чанарын гадаад үнэлгээнд хамрагдаж гэрчилгээ авсан. | Молекул биологи, иммунологи, иммуногематологи, бүлэгнэлтийн гадаад үнэлгээний сорьц тээвэрлэгдэж ирсэн тухай бүрт хамрагдаж гэрчилгээ авсан байна. | Бүлэгнэлтийн шинжилгээгээр: 2 сарын 24-нд дэлхийн гемофилийн холбооны ЧГҮХ-т 3 үзүүлэлтээр оролцож А үнэлгээ авсан.<br><br>2022 оны 4 сарын 25-нд Иммунологийн шинжилгээгээр НЭМҮТ-тэй лаборатори хоорондын харьцуулалт хийж 100% тохирсон үр дүн гарсан.<br><br>Иммунологийн шинжилгээгээр 6 сард ХӨСҮТ-ийн иммунологийн шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээний 17дах удаагийн хөтөлбөрт 100% үр дүнтэй хамрагдсан. 11сарын 16–нд 18дах удаагийн үнэлгээнд хамрагдсан, үр дүн гараагүй.<br><br>Иммуногематологийн шинжилгээгээр Австралийн RCPAQAP Transfusion Competency Survey-5 хөтөлбөрт 9 сард 93% үр дүнтэй хамрагдсан. 10 сард Survey-6 хөтөлбөрт 100% үр дүнтэй хамрагдсан.<br><br>Молекул биологийн чиглэлээр сорьц тээвэрлэгдэж ирээгүй шалтгаанаар гадаад хяналтанд оролцож чадаагүй. иммунологийн шинжилгээгээр мөн ОУ-ын хяналтанд орж чадаагүй. Үндэсний ЧГҮ-ний хөтөлбөрт хамрагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | **СТЗ 3.2**<br>Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын чиглэлээр үндэсний чанарын гадаад үнэлгээнд хамрагдана. | 380.0 Улсын төсөв | Чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан гэрчилгээ | 2021 онд Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд тус бүр 1-с дээш удаа хамрагдаж гэрчилгээ авсан. | Гематологи, биохими, нян судлалын шинжилгээний чиглэлээр тус бүр 1 удаа чанарын гадаад үнэлгээнд хамрагдаж гэрчилгээ авсан байна. | Гематологийн шинжилгээний 28 дах удаагийн үнэлгээнд харьцангуй үнэлгээ-82,5%, үнэмлэхүй үнэлгээ-96,68%, биохимийн шинжилгээний 22 дах удаагийн үнэлгээнд харьцангуй үнэлгээ-100%, үнэмлэхүй үнэлгээ-100% сайн үр дүнтэй оролцсон.<br><br>Бүлэгнэлтийн шинжилгээний 2 дах удаагийн үнэлгээнд 93,3% үнэлгээтэй оролцсон.<br><br>2022.11.16–д 29 дах удаагийн гематологи, 3дах удаагийн бүлэгнэлтийн шинжилгээний гадаад хяналтанд оролцсон. Үр дүн гараагүй байна.<br><br>Нян судлалын шинжилгээгээр 12 сарын 12-нд УХТЭ-ийн Нэгдсэн лабораторийн тасагтай лаборатори хоорондын харьцуулалт хийж, тохирсон гэсэн үр дүн гарсан. | 100% |
| 34. | **ЗГҮАХ 2.1.9**<br>Ижил мэргэжилтний үнэлгээг тогтмол хийнэ. | - | Үнэлгээ хийсэн тоо, батлагдсан журам | 2021 онд Ижил мэргэжилтний үнэлгээг нийт 30 удаа зохион байгуулсан. | Ижил мэргэжилтний үнэлгээний журам шинээр батлуулж, журмын дагуу 30-аас доошгүй удаа үнэлгээ хийсэн байна. | ЭМС-ын 2019 оны А/566 тушаалын дагуу “Ижил мэргэжилтний үнэлгээний журам” Ж-2-ЕР-45-01 боловсруулж, 2022 оны 6 дугаар сараас мөрдөж эхэлсэн.<br>Ижил мэргэжилтний үнэлгээ хийх хуваарь гарган 45 мэргэжилтнийг хамруулсан ба<br>- ДЗБТ - 21 сувилагч хамрагдаж 98%<br>- ҮТ 9 технологич сувилагч оролцож 100%<br>- НЛТ- 5 лаборант оролцож 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - ИТТ тасаг 2 жолооч, 2 инженер оролцож 100%<br>- СҮА-6 үйлчлэгч оролцож 95% тус тус үнэлэгдсэн.<br>Үнэлгээний дүнд үндэслэн давуу тал, сайжруулах саналыг ДЗБТ-т 1, СҮА-д 2 санал хүргүүлсэн. | |
| 35. | **СТЗ 4.1** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлын бүртгэлийг сайжруулж, хариу арга хэмжээ авах, сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | - | Нийт бүртгэгдсэн тохиолдлын тоо, давтан бүртгэгдсэн тохиолдлын хувь | 2021 онд 57 тохиолдол бүртгэгдсэнээс, давтан бүртгэгдсэн тохиолдол 84 хувийг эзэлж байна. | Тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол бүрийг бүртгэж, тохиолдлын эх сурвалжийг олж засах, ижил төрлийн тохиолдол давтан гарахаас сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. | Ерөнхий захирлын 2022 оны А/03 дугаар тушаалаар "Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах баг"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, багийн төлөвлөгөөнд 7 ажил тусган хэрэгжүүлж, биелэлт 95,7% байна. 2022 оны 4 дүгээр сараас эхлэн ЭМХТ-өөс eburtgel.moh.gov.mn тохиолдлын цахим санг үүсгэн тохиолдлуудыг бүртгэж эхэлсэн. Төвийн 65 ажилтанд тохиолдлын цахим санд нэвтрэх эрх үүсгэж, цахим санд тохиолдол бүртгэх заавар боловсруулж, алба тасгуудад түгээсэн.<br><br>2022 оны 12 сарын 06-ны өдрийн байдлаар 39 тохиолдол цахим санд бүртгэгдсэнээс 37 тохиолдол залруулагдсан. 2022 онд нийт 149 тохиолдол бүртгэгдсэнээс 58% нь хувь хүний үйл ажиллагаатай холбоотой буюу гуурс кодны зөрүү эзэлж байв. Иймээс ЦЧАБА-аас 2021 оноос 2022 оны 8 дугаар саруудад бүртгэгдсэн 180 тохиолдлуудад дүн шинжилгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, хурлын шийдвэрээр "Танин тодруулалтыг хийж хэвшүүлье" 14 хоногийн аяныг 8 дугаар сарын 24-ны өдрөөс 9 дүгээр сарын 9-ны өдрийн хооронд зохион байгуулж, 4 арга хэмжээ төлөвлөн амжилттай хэрэгжүүлсэн. Аяны үр дүнд 4 дүгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улиралд гуурс код зөрсөн тохиолдлын тоо өмнөх улирлаас 50%-иар буурсан. | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 4.** ЛАВЛАГАА ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ ХАРИЛЦАГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭЛТЭД НИЙЦҮҮЛНЭ. | | | | | | | |
| 36. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 4.1**<br>Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуногематологийн лавлагаа шинжилгээг хийнэ. | 132.2 Улсын төсөв | Лавлагаа шинжилгээний нэр, төрөл, тоо, тохирлын хувь. | Хувийн тохироо тодорхойлох, эргэлзээтэй бүлэг тодорхойлох, кумбсын шууд ба шууд бус урвал, эсрэг бие илрүүлэх, дүйн тодорхойлох, резус сөрөг баталгаажуулах, анти-Д титр тодорхойлох, резусийн дэд бүлэг тодорхойлох 7 нэр төрлийн шинжилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хийсэн. | Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуногематологийн лавлагаа шинжилгээг 100% хийж, хариуг олгосон байна. | 2022 онд үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу дараах шинжилгээг 100% хийж хариуг тухай бүр олгож ажилласан байна. Үүнд:<br>● Анти-Д титр тодорхойлох- 669<br>● Кумбсын шууд ба шууд бус урвал-526<br>● Резус сөрөг баталгаажуулах- 136<br>● Резусийн дэд бүлэг тодорхойлох-258<br>● Хувийн тохироо тодорхойлох- 244<br>● Эргэлзээтэй бүлэг тодорхойлох-19<br>● Эсрэг бие тодорхойлох-105<br>● Эсрэг бие дүйн тодорхойлох- 46<br>● Нярайн бүлэг, резус тодорхойлох- 3<br>● элэг шилжүүлэхийн хувийн тохироо-824 | 100% |
| 37. | **СТЗ 4.1**<br>Цусны бүлэг, хувийн тохирооны Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 5.6 Улсын төсөв | Үндэсний чанарын гадаад үнэлгээний гэрчилгээ авсан Эрүүл мэндийн | 2021 онд 2 удаа зохион байгуулж 85 байгууллагад Үндэсний чанарын гадаад үнэлгээний | 17, 18 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, | 2022 оны 3 сарын 24-нд цусны бүлэг хувийн тохирооны 16 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын тоо | гэрчилгээ олгосон. | оролцсон байгууллагуудад гэрчилгээг олгосон байна. | оролцогч лабораториудад тайланг танилцуулж, сертификат олгосон.<br><br>17 дах үнэлгээг 6 сарын 23-нд зохион байгуулж, 90 багцыг бэлтгэж 85 лабораторит тараасан. 9 сарын 21-нд “Лабораторийн шинжилгээний чанар хангалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт тайлан семинарыг зохион байгуулж үнэлгээний үр дүн, оролцогчдын сертификатыг оролцогч лабораториудад тараасан.<br><br>2022 оны 11 сарын 16-нд 18 дах үнэлгээг зохион байгуулж 95 лабораторит хяналтын багцыг тараагаад байна. 2022.11.23-нд оролцогч лабораториудад тохироо зөв хариуг илгээсэн ба 2023 оны эхний улиралд тайлан семинарыг зохион байгуулж, сертификатыг олгоно. | |
| 38 | **СТЗ 4.1**<br>Цусны бүлэгнэлтийн шинжилгээний Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 8.0<br>Улсын төсөв<br>Ханган нийлүүл эгч байгуул лага | Үндэсний чанарын гадаад үнэлгээний гэрчилгээ авсан Эрүүл мэндийн байгууллагын тоо | 2021 онд 6 сард туршилтын, 12 сард анхны үнэлгээг зохион байгуулж 108 байгууллагад Үндэсний чанарын гадаад үнэлгээний гэрчилгээ олгосон. | 2, 3 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, оролцсон байгууллагуудад гэрчилгээг олгосон байна. | 2022 оны 3 сарын 24-нд цусны бүлэгнэлтийн шинжилгээний 1 дэх удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, оролцогч лабораториудад тайланг танилцуулж, сертификат олгосон. 2022 оны 6 сарын 23-нд цусны бүлэгнэлтийн шинжилгээний 2 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг зохион явуулахаар төлөвлөн 90 багцыг савлан бэлтгэж тараасан. Тайлан семинарыг 2022 оны 11 сарын 4-нд зохион явуулж, 80%-с дээш үнэлгээтэй 40 лабораторит сертификат олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022.11.16-нд 3 дах удаагийн үнэлгээг зохион байгуулж 86 лабораторит хяналтын багцыг тараасан. 2012 оны 12 сарын 09-нд тайланд боловсруулалт хийж оролцогч лабораториудад хариуг илгээсэн. 2023 оны эхний улиралд тайлан семинарыг зохион байгуулж, сертификатыг олгоно. | |
| 39. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 4.2** Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын магадлах аудитад хамрагдана. | 3.6 Улсын төсөв | Магадлах аудитын тайлан, зөвлөмж | 2021 онд магадлах аудитад амжилттай хамрагдсан. | 2022 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын магадлах аудитад хамрагдсан байна. | 2021 оны Чанарын менежментийн тогтолцооны магадлах аудитын сайжруулах саналын тайланг хэрэгжүүлсэн. Биелэлт 93,7%.<br>2022 оны төлөвлөгөөний дагуу магадлах аудитад хамрагдаж MNS ISO 9001:2016 стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байна гэж дүгнэлээ. | 100% |
| 40. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 4.2** Лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага 15189:2015 стандартыг тогтвортой хэрэгжүүлнэ. | 0.8 Улсын төсөв | Магадлах аудитын тайлан, зөвлөмж | 2021 онд магадлах аудитад амжилттай хамрагдсан. | 2022 онд Лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага 15189:2015 стандартын магадлах аудитад хамрагдсан байна. | 2022 оны 4 дүгээр сард стандартын техникийн хорооны хурал зохион байгуулагдаж, ISO 9001:2015 стандартыг тогтвортой хэрэгжүүлж байгааг үнэлэн гэрчилгээг 4 жилээр сунгасан.<br>Үндэсний Итгэмжлэлийн төвтэй гэрээг шинэчлэн хийсэн. | 100% |
| 41. | **СТЗ 4.1** Цусны салбар төвүүдэд цусны | 4.4 Улсын төсөв | Хяналт үнэлгээний | 2021 онд цусны 2 салбар төвд дэмжлэгт хяналт | Цусны салбар төвийн үйл ажиллагаанд | 2022 онд цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх удирдамж боловсруулан, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана. | | тайлан, зөвлөмж. | үнэлгээ хийж, тайлан зөвлөмжийг хүргүүлсэн. | дэмжлэгт хяналт үнэлгээг цахим болон газар дээр нь хийж мэргэжил арга зүйгээр хангасан байна. | нийт 5 эрүүл мэндийн байгууллагад цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. Үүнд:<br>- 2 сарын 20-ны өдөр Говь-Алтай аймгийн ЦСТ-д 2 хүнтэй баг<br>- 4 дүгээр сарын 29-ны өдөр Налайх цусны салбар төвд 3 хүнтэй баг,<br>- 5 сарын 23-нд ХСҮТ-д 5 хүнтэй баг<br>- 6 дугаар сарын 27-ны өдөр Төв аймгийн ЦСТ-д 5 хүнтэй баг,<br>- 7 дугаар сарын 5-ны өдөр Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт 4 хүний бүрэлдхүүнтэй баг тус тус ажиллаж, үнэлгээгээр илэрсэн сайн тал, сайжруулах саналыг хүргүүлж ажилласан. | |
| 42. | **ЗГҮАХ 2.1.8; СТЗ 4.1**<br>Гемофилийн эсрэг факторыг хүлээн авах, хуваарилах, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 1,124.8 Улсын төсөв | Амбулаториор урьдчилан сэргийлэх факторыг захиалгын дагуу авсан хүний тоо, олгосон тун нэгжээр. | Гемофили А-тай 85 хүнд 2.866.250 ОУН VIII фактор, гемофили В-тэй 32 хүнд 831,000 ОУН IX факторыг олгосон. | Амбулаториор урьдчилан сэргийлэх тунгаар VIII, IX факторыг эмчийн жорын дагуу бүрэн олгосон байна. | 2022 онд урьдчилан сэргийлэх тунгаар олгодог VIII, IX факторыг эмчийн жорын дагуу бүрэн олгож ажилласан. Үүнд:<br><br>8-р фактор 63 хүнд 2,622,000 ОУН, 9-р фактор 27 хүнд 624,000 ОУН тус тус олгосон.<br><br>Дэлхийн Гемофилийн холбооны тусламжийн факторын импортын лицензийг авахад бүрдүүлэх материлыг холбогдох газар хүргүүлж, хүлээн авсан<br><br>Монголын Гемофилийн холбооны хүсэлтээр “Гемофилийн тусламж үйлчилгээ, 2019-2021 оны факторын хэрэглээ” сэдэвт мэдээллийг үйлчлүүлэгч, МГХ, ар гэрийхэнд хүргэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 43. | **СТЗ 4.1** Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийг мэдээлэх тогтолцоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - | Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын ажилтны тоо | 2021 онд цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийн талаар сургалт зохион байгуулаагүй. | Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийн талаар сургалтын материал бэлтгэн, гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан байна. | Төвийн олгох хэсэгт ЦЦБ хэрэглэгч гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжилтнүүдэд “Цус сэлбэлтийн цочмог урвал хүндрэл ба урвал хүндрэл мэдээлэх заавар”-ыг боловсруулан байршуулсан. Мөн урвал хүндрэлийг хүлээн авах маягтыг шинэчлэн боловсруулсан. ЭШМТА-тай хамтран “Цусны чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээг төлөвшүүлье” сэдэвт багц цагийн сургалтын удирдамж батлуулан 2 эрүүл мэндийн байгууллагад сургалт хийсэн. | 100% |
| 44. | **СТЗ 4.1** Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлнэ. | 1.0 Улсын төсөв | Төлөвлөгөө, тайлан | 2 сарын аян зохион байгуулан 11 ажил төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн. | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 3 сарын аяны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдрийн 6 зорилтын хүрээнд 2022 оны “Эмийн хэрэглээний аюулгүй байдал-Эмийг зөв хэрэглэе” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн ба энэ хүрээнд Эмийг зөв хэрэглэх 5 алхамын брошур танилцуулгыг хэвлэн, олон нийтэд хүргэх, өндөр эрсдэлтэй эм тарианы жагсаалт, зургыг шинэчлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнээс гадна 6 зорилтын хүрээнд төвийн 1, 2-р байранд унах эрсдлийг үнэлэх шалгуур хуудас боловсруулж, үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээнүүдийг жилийн турш зохион байгуулсан. | 100% |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 5.** МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭН, ИННОВАЦИ НЭВТРҮҮЛНЭ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45. | **ЗГҮАХ 2.4.1; СТЗ 5.2** Цус сэлбэлт судлалын салбарын онол, практикийн XIX бага хурал зохион байгуулна. | 1.0 Улсын төсөв | Хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуй | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XYIII бага хурал зохион байгуулагдсан. | Цус сэлбэлт судлалын салбарын онол, практикийн XIX бага хурал зохион байгуулагдаж, илтгэлийн хураангуйг хэвлүүлсэн байна. | ЭШБХ-ийн удирдамж, хөтөлбөрийг батлуулан, Ерөнхий захирлын 2022 оны 10 дугаар сарын 14-ны А/65 тушаалын дагуу “Цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт бага хурлыг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 9 илтгэл хэлэлцүүлж, тайланг бичсэн. Илтгэлийн хураангуйг хэвлүүлсэн. | 100% |
| 46. | **СТЗ 5.2** Цус сэлбэлт судлалын салбарын “Үндэсний семинар”-ыг зохион байгуулна. | 1.5 Улсын төсөв | Цахим семинарын хөтөлбөр, удирдамж, тайлан. | 2021 онд “Үндэсний цахим семинар”-ыг зохион байгуулсан. | Үндэсний цахим семинар зохион байгуулагдсан байна. | Цус сэлбэлт судлалын салбарын “Үндэсний семинар”-ын удирдамж, хөтөлбөрийг батлуулан, Ерөнхий захирлын А/19 тушаалын дагуу зохион байгуулж нийт 80 эмч, мэргэжилтнүүдэд 1.5кр олгосон. | 100% |
| 47. | **СТЗ 5.1** Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг, Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. | - | Байгууллагын гишүүнчлэл Хамтран хэрэгжүүлсэн ажлын тайлан | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT) 2021 оны гишүүнчлэлээ сунгасан. 2019 онд Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-той 4 жилийн хугацаатай Санамж бичиг байгуулсан. | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг (ISBT) -тэй 2022 оны гишүүнчлэл сунгаж хамтран ажилласан байна. AATM-тай санамж бичигт заасан хамтын ажиллагаа хэрэгжсэн байна. | -ISBT-ийн 2022 оны гишүүнчлэл сунгуулах материалыг бүрдүүлэн гэрчилгээг авсан.<br>-AATM-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хамтарсан цахим уулзалтыг 2 удаа зохион байгуулсан, гишүүдийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн явуулсан.<br>-AATM-ын GJTM сэтгүүлд “Current State of Blood Transfusion Service in Mongolia” өгүүлэлийн засварыг хийж хэвлүүлсэн.<br>-AATM-ын гишүүн 14 орон нэгдсэн байдлаар ЦДДӨ-ийг 6-р сарын 14-д зохион байгуулахад оролцсон. ЦССҮТ-ийн талаарх Success story-г ДЗБТ-тай хамтран хийж явуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -ЦДДӨ-ийн үйл явдлын техникийн бэлэн байдлыг ханган шууд дамжуулалтыг Zoom room-д хийсэн.<br>-БНХАУ-ын Шанхайн Цусны төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. | |
| 48. | **МУХТЖҮЧ 2.2.8; ЗГҮАХ 2.1.9; СТЗ 5.3**<br>Цусны аюулгүй байдлыг хангах чиглэлээр багц цагийн сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 2021 онд “Цусны аюулгүй байдал” сургалтыг 1 удаа зохион байгуулсан.<br>Цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох багц цагийн сургалтад 11 эмнэлгийн 40 эмч, мэргэжилтнийг хамруулсан. | Цусны аюулгүй байдал, цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох багц цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна. | “Цусны аюулгүй байдлыг хэвшүүлье” багц цагийн сургалтын удирдамж, хөтөлбөрийг батлуулан 1 удаа зохион байгуулж нийт 36 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1кр олгосон.<br>“Цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох аргачлал” багц цагийн сургалтын удирдамж, хөтөлбөрийг батлуулан 2 удаа зохион байгуулж нийт 100 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 0.5 кр олгосон. | 100% |
| 49. | **МУХТЖҮЧ 2.2.8; ЗГҮАХ 2.1.9; СТЗ 5.3**<br>Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын их эмчийн төрөлжсөн, цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх | - | Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал | 2021 онд Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын их эмчийн мэргэшүүлэх сургалтыг 4 эмч цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх | Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын их эмч мэргэшүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. | 2022 онд төрөлжсөн мэргэжлийн сургалтаар 9 их эмч, 3 био-анагаахын мэргэжилтэн нийт 12, мэргэшүүлэх сургалтаар 5 сувилагч нийт 17 суралцагч суралцаж төгссөн.<br>1. 2022 оны 06 сарын 03-ны ЭМС-ын А/302 дугаар тушаалын дагуу Эмнэлзүйн цус сэлбэлт судлал-2 их эмч, ,Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи-1 био-анагаахын мэргэжилтэн<br>2. 2022 оны 02 сарын 28 ЭМХТ-ийн захирлын А/17 тоот тушаалаар нар “Цус, цусан бүтээгдэхүүний технологич”-2 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр сургалт зохион байгуулна. | | | сургалтыг 4 сувилагч төгссөн. | | 3. 2022 оны 11 сарын 29-ний өдрийн ЭМХТ-ийн захирлын дээшлүүлэх сургалтын А/138 дугаар тушаалын дагуу Цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагч-3<br>4. 2022 оны 12 сарын 11-ний ЭМС-ын А/576 дугаар тушаалаар Эмнэлзүйн цус сэлбэлт судлал-7 их эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи-2 био-анагаахын мэргэжилтэн<br>2022 онд төрөлжсөн мэргэжлийн сургалтаар 9 их эмч, 3 био-анагаахын мэргэжилтэн нийт 12, мэргэшүүлэх сургалтаар 5 сувилагч нийт 17 суралцагч суралцаж төгссөн байна.<br>ЭМС-ын А/533, А/276 дугаар тушаалын дагуу 2022 оны 10-р сарын 1-ээс Эмнэл зүйн цус сэлбэлт судлалын их эмчийн төрөлжсөн мэргэшлээр 8 эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологич-1 био-анагаахын мэргэжилтэн, ЭМХТ-ийн захирлын А/120 тушаалын дагуу сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 сувилагч нийт 11 суралцагч элсэн суралцаж байна. | |
| 50. | **МУХТЖҮЧ 2.2.1: ЗГҮАХ 2.1.9; СТЗ 5.4**<br>ЦССҮТ-ийн “Донор аппликейшн”-ийг шинэчлэн хөгжүүлнэ. | - | Шинээр хийсэн аппликейшн | Одоо байгаа аппликейшн зөвхөн андройд үйлдлийн системд ажилладаг. | Андройд болон IOS үйлдлийн системд ажилладаг шинэ аппликейшн ашиглалтад оруулсан байна. | МУЗН-тэй хамтран “Цусны донор” аппликейшнийг Android ба IOS үйлдлийн системд бүрэн нэвтрүүлэн ашиглаж байна.<br>“Цусны донор” аппликейшныг ашигласнаар донор хэдэн удаа цусаа өгсөн, хамгийн сүүлд хэзээ цусаа өгсөн, цус сэлбэлтээр дамжих халдвар илэрүүлэх шинжилгээний хариуг харах, цусны бүлгийн мэдээлэл болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмдэглэлт өдрүүд, төвийн үйл ажиллагааны зарим мэдээллийг авах боломж бүрдсэн. Энэ нь донорын цагийг хэмнэж сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн. | |
| 51. | **МУХТЖҮЧ 2.2.6: ЗГҮАХ 2.1.9; СТЗ 5.4**<br><br>Иргэдийн цусны бүлгийн мэдээллийг “E-Mongolia” нэгдсэн системд бүрэн оруулж, баяжилт хийнэ. | - | Бүртгэгдсэн донор, үйлчлүүлэгчийн мэдээлэл | E-Mongolia системд цусны донор, үйлчлүүлэгчдийн цусны бүлгийг мэдээллийг харуулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн. | E-Mongolia” нэгдсэн системд ЦССҮТ, Цусны салбар төвд бүртгэлтэй нийт донор үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн мэдээллийг харах боломж бүрдсэн байна. | Цус сэлбэлт судлалын салбараар үйлчлүүлсэн бүртгэлтэй нийт цусны донор үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн мэдээллийг “E-Mongolia” нэгдсэн системд 2022 оны 4 сарын 27-ны өдрөөс оруулсан. e-Mongolia нэгдсэн системээс цусны бүлгийн мэдээллийг харах боломжтой болсон. 2022 оны 4 сарын 27-оос 2022 оны 12 сарын 6-ныг хүртэл нийт 17995 донор, үйлчлүүлэгч цусны бүлгийн мэдээллээ харсан байна. | 100% |
| 52. | **МУХТЖҮЧ 2.2.6: СТЗ 5.4**<br>Донорын эрүүл мэндийн картыг цахимжуулж, CallPro, Chatbot үйлчилгээний хэрэглээг чанаржуулна | 4.0 Улсын төсөв | Донорын эрүүл мэндийн цахим карттай донорын тоо, CallPro, Chatbot үйлчилгээний тайлан | Донорын эрүүл мэндийн карт цаасан хэлбэртэй. CallPro, Chatbot үйлчилгээний дашбаорд эрхийг сэргээсэн. | Цус цуглуулах суурин төвөөр үйлчлүүлсэн бүх доноруудад цахим эрүүл мэндийн картыг ашиглуулж эхэлсэн байна. CallPro, Chatbot үйлчилгээг ашиглан үйлчлүүлэгч мэдээллээ тогтмол авах боломжийг хангасан байна. | “Цусны донор аппликейшн”-д Донорын эрүүл мэндийн картыг цахимаар холбосон. Донорын эрүүл мэндийн цахим карттай 2600 гаруй донор байна. Callpro ХХК-тай хамтран ажиллах гэрээг 2022 оны 03-р сарын 09-нд шинэчлэн хийсэн. Түгээмэл асуулттай холбоотойгоор шинжилгээний хариу авах цэсийг үйлчилгээнд нэмсэн. Нийт 3 дугаараар үйлчлүүлэгчдэд мэдээ, мэдээллийг тогтмол өгдөг. ЦССҮТ-ийн чатботын 4 төрлийн цэснээс, 15 төрлийн үйлчилгээг авах боломжтой энэ нь үйлчлүүлэгчдийг цаг алдалгүй шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Chat bot: 2022 онд нийт 3,406 хэрэглэгч чат бот асуулгад хамрагдсан байна. Үүнээс 2,890 шинэ хэрэглэгч байна.<br>Call pro: 2022 онд нийт давхардсан тоогоор 4155 дуудлага ирсэн. | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 6.** МЭДЛЭГ ЧАДВАРТАЙ АЛБАН ХААГЧДЫГ ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖООР БҮРЭН ХАНГАНА. | | | | | | | |
| 53. | **МУХТЖҮЧ 2.2.8; ЗГҮАХ 2.1.9; СТЗ 6.1**<br>“Төвийн хүний нөөцийн хөгжлийг хангах 2021-2025 оны хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | 2022 оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Хүний нөөцийн хөгжлийг хангах 2021 оны төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. | Хүний нөөцийн хөгжлийг хангах 2022 оны төлөвлөгөө 100% хэрэгжсэн байна. | Хүний нөөцийн хөгжлийг хангах 2022 оны төлөвлөгөөний биелэлт 100% хэрэгжсэн байна. Байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтийг 98-100% байлгаж, холбогдох сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн мэргэшсэн хүний нөөцөөр нөхөн хангахад анхааран ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн хууль /шинэчилсэн найруулга/-тай уялдсан Хамтын гэрээ байгуулан бүртгүүлж, Хөдөлмөрийн дотоод журам, түүнтэй уялдан гарах Сонгон шалгаруулалтын журам, Хүний нөөцийн төлөвлөлтийн журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Ур чадварын нэмэгдэл олгох журам, мөнгөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урамшууллын журам, Цалин хөлсний журмыг тус тус батлуулан, Шагнал урамшуулын журмын төсөл боловсруулан ҮЭСХ, Алба, тасгийн саналыг авч нэгтгэн Ажлын хэсгийн хурлаар хэлэлцээд байна. | |
| 54. | **ЗГҮАХ 2.1.10; СТЗ 6.6**<br>ХАБЭА-н Удирдлагын тогтолцоо-шаардлага MNS ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлнэ. | 4.0<br>Улсын төсөв | Баталгаажуулалтын гэрчилгээ | ISO 45001:2018 стандарт нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн. | ХАБЭА-н Удирдлагын тогтолцоо-шаардлага MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж, гэрчилгээ авсан байна. | ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны OHSAS 18001:2012 стандартаас ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны MNS ISO 45001:2018 стандарт руу шилжих ажлын бэлтгэлийг 2021 оноос эхлэн ханган ажилласан.<br><br>2022 онд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэхэд туслах зөвлөх үйлчилгээний гэрээг “Менежментийн тогтолцооны мэргэжилтнүүдийн холбоо” ХХК-тай байгуулан ажиллаж, стандартын баталгаажуулалтад хамрагдах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br><br>● Ерөнхий захирлын тушаалаар стандарт нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулав.<br>● Зөрүүгийн шинжилгээ хийлгэж оношилгооны нэгдсэн дүнд үндэслэн төлөвлөгөө боловсруулав.<br>● ХЭМАБ-ын гарын авлага боловсруулав.<br>● ХЭМАБ-ын зөвлөл, ажлын хэсэгтэй хамтран төвийн хэмжээнд мөрдөж буй журмууд, ХЭМАБ-ын тогтолцоо, ХЭМАБ-ын бодлого, зорилтод 3 удаагийн аудит хийв.<br>● Аудитын үр дүнд УДШ хийлгэж залруулах болон сайжруулах ажлуудын төлөвлөгөө боловсруулав. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● ХЭМАБ-тай холбоотой 19 журамд үнэлгээ хийж, 5 журмыг шинэчлэн боловсруулсан.<br>● Зөвлөх багаас нийт 13 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 89 ажилтанг хамруулав.<br>● Дээд удирдлагын баг, дунд шатны удирдлагын баг, ХЭМАБ-ын зөвлөлийн 24 гишүүдийг М2 түвшиний сургалтад хамруулав.<br>● Менежментийн тогтолцооны М1 түвшний сургалтад нийт ажиллагсдыг хамруулав.<br>● ХНХЯ-ны 2019 оны А/370 тоот тушаалын дагуу “Ажил олгогчдыг чадавхижуулах” сургалтад 12 ажилтанг хамруулав.<br>● ХАБ-ын мэдлэг олгох нийт ажиллагсдын 12 цагийн сургалтад нийт ажиллагсдыг хамруулав.<br><br>Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэн, 2022.12.02-нд СХЗГазарт ISO 45001:2018 стандартын баталгаажуулалт хийлгэхээр хүсэлт гарган холбогдох материалуудыг хүргүүлсэн. | |
| 55. | **МУХТЖҮЧ 2.2.8; ЗГҮАХ 2.1.9; СТЗ 6.4**<br>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | 15.0 Улсын төсөв | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2021 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг НЭМҮТ, ЭМЯ-д хүргүүлсэн. | 2022 оны төлөвлөсөн арга хэмжээ 100% хэрэгжсэн байна. | Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 оны төлөвлөсөн арга хэмжээ бүрэн биелсэн. Хамтын гэрээний төслийг ҮЭ-ийн саналыг тусган боловсруулсан бөгөөд ажилтнуудыг аарцаар үйлчлэх, амралтын өдөр ажилласан зарим ажилтанд урамшуулал олгох, ажилтнуудад байгууллагын зардал болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандивлагчдын дэмжлэгээр дархлаа дэмжих багц олгох ажлыг хэрэгжүүлэв. Төвийн Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт дуусахтай холбоотой тэдний нийгмийн асуудлыг дэмих үйл ажиллагааг төвийн зардлагын хэмнэлт, өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Цусны донорын тухай хуулийн төсөл боловсруулах хүрээнд холбогдох зохицуулалт тусган ажиллаж байна.<br>ҮЭХ-той хамтран МУЗН-ийн 4.800.000 төгрөгийн буцалтгүй тусламж 24 ажилтанд үзүүлсэн. | |
| 56. | **МУХТЖҮЧ 2.2.8; ЗГҮАХ 2.1.9; СТЗ 6.2**<br>Төвийн эмч, мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалтад хамруулна. | - | Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан ажиллагсдын тоо | Хамтын гэрээний 4.12, ЦССҮТ-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.2.4 заалтад үндэслэн ЭМХТ-ийн 2021 оны 4 сарын 26-ны А/44 дугаар тушаалаар ДЗБТ-ийн сувилагч Б.Билгүүн “Цус, цусан бүтээгдэхүүний технологич”-иор төгссөн. ЭМС-ын А/653 тушаалаар Б.Оргил, ЭМХТ- | Төвийн эмч мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалтад хамруулсан байна. | -Хамтын гэрээний 4.12, ЦССҮТ-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.2.4 заалтад үндэслэн төвийн 5 эмч, 2 сувилагч нийт 7 ажилчдыг төгсөлтийн дараах сургалтад хамруулсан. Үүнд: ЭМХТ-ийн захирлын А/17 дугаар тушаалаар сувилагч Б.Танхилмаа, Б.Хишигням нар “Цус, цусан бүтээгдэхүүний технологич”, ЭМС-ийн 2022 оны А/302 дугаар тушаалаар Б.Оргил, А/276 дугаар тушаалаар Б.Солонго, Д.Туул, А.Амарзаяа, Ч.Тунгалаг нар “Эмнэлзүйн цус сэлбэлт судлал” чиглэлээр тус тус суралцан төгссөн.<br>-Б.Солонго АШУҮИС-ийн “Молекул биологи судлал” чиглэлээр, Ж.Нармандах “Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт” чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн сургалтад тус тус хамрагдсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ийн захирлын А/130 тушаалаар 2 сувилагч нийт 3 суралцагч элсэн суралцаж байна. | | -Ж.Нармандах, Д.Дуламсүрэн нар ЭМХТ-ийн захирлын А/66 дугаар тушаалаар “Сувилахуйн сургагч багш”-ийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.<br>-Ж.Нармандах ЭМХТ-ийн А/105 дугаар тушаалаар “Эмнэлзүйн чиглүүлэгч багш”-ийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.<br>-Б.Өнөрцэцэг 2022.09.21-24 Монголын сувилагчдын нийгэмлэгээс зохион байгуулсан “Эмнэлгийн халдвар хяналтын сувилагч бэлтгэх” сургалтад хамрагдсан.<br>-Б.Идэржавхлан ЭМХТ, ХӨСҮТ-д Ариутгал судлал чиглэлээр суралцаж байна. 2022 онд нийт давхардсан тоогоор 8 эмч, сувилагч төрөлжсөн мэргэжлийн, 3 сувилагч дээшлүүлэх, 2 сувилагч сургагч багш, 1 сувилагч чиглүүлэгч багш, халдвар хяналтын сувилагчаар 1 нийт 14 ажилтан төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 57. | **СТЗ 6.2**<br>Төвийн ажиллагсдын ёс зүй харилцаа хандлага, хариуцлагыг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ. | 0.5<br>Улсын төсөв | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Жил бүр төлөвлөгөө гарган ажиллаж хэрэгжилтийг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд тайлагнадаг. | Ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангаж ажилласан байна. | "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" багц цагийн цахим сургалтанд /ЭМХТ-ийн HRDS/ 2022.09.16-нд АШУҮИС-Эрдмийн сургуулиас 1 багц цагийн кредиттэй Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалтад нийт 36 ажилтан хамрагдсан.<br>Ажилтаны ёс зүй харилцаа, хандлагыг асуумжаар авч, нэгтгэн дүгнэхэд:<br>- Эмнэлгийн үйлчлүүлэгч: ЦЦБ-ний түгээх хэсгийн үйлчилгээний ажилтаны харилцаа, хандлага, ёс зүй 98% маш сайн, сайн, дунд 1%, муу 1% гэж үнэлсэн<br>- Донор үйлчлүүлэгч: Мэргэжилтний үйлчлүүлэгчтэй харилцах ёс зүй сайн 78%, дунд 20,5%, хангалтгүй 1,5%<br>- Төвийн ажилчдын үнэлгээ: Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сайн 80,4%, дунд 19,6 үнэлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын ажилтны ёс зүйн сайн 74,9%, дунд 25,1% гэж үнэлсэн байна.<br>Донор үйлчлүүлэгч, эмнэлгийн үйлчлүүлэгч, төвийн ажилчидаас сэтгэл ханамжийн судалгааг (docs.google.com) авч, нэгтгэсэн, үүнд:<br>- Нийт 3 удаа 308 донор, үйлчлүүлэгчээс авсан үүнд: Ерөнхий сэтгэл ханамж маш сайн 82,6%, дунд 16.3, муу 1, 2 байна% гэж үнэлсэн байна<br>- ЦЦБ-ийг хэрэглэгч эмнэлгийн 82 мэргэжилтнээс авсан сэтгэл ханамж судалгаа асуумжаар авч, нэгтгэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэхэд: Ерөнхий сэтгэл ханамж маш сайн 59%, сайн 40%, муу 1% гэж үнэлсэн байна.<br>- Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас 2 удаа давхардсан тоогоор 106 асуумж авснаас, Ерөнхий сэтгэл ханамж 78,6% байна.<br>Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, танилцуулсан. | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА Ч.БАТБОЛД

ХЯНАСАН:
ДОТООД АУДИТОР Э.ТУНГАЛАГТУЯА